



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/191

Сүхбаатар сум

### Шагнах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Боловсролын тухай хуулийн 43 дүгээр зүйлийн 43.1.1, 43.2.7, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 81 тоот тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, Монгол Улсын Сангийн сайдын 2012 сны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020-2021 оны хичээлийн жилд зохион байгуулсан элсэлтийн ерөнхий шалгалтад монгол хэлний хичээлээр 800 оноо авсан Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн зурагч Амаржаргалын Сумъяасүрэн бэлтгэсэн багш А.Баянжаргал нарт баяр хүргэж, хавсралтад зааснаар шагнаж урамшуулсугай.

2. Шагналын 1500000 /нэг сая таван зуун мянган /төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга О.Мөнхбаярт зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2020 оны 07 дугаар сарын 10-ны дотор гаргаж ирүүлэхийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга Ч.Жаргалсайханд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 07-р сарын 09-ны өдрийн  
А/191 дугаар захирамжийн хавсралт

Шагнал олгох зардлын төсөв

2020.07.08

№	Овог нэр,	Сургууль, албан тушаал	Нэг бүрийн мөнгө	Дэмжлэгийн мөнгөн дүн /төгрөг/
1	А.Сумъяасүрэн	Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагч	1000000	1000000
2	А.Баянжаргал	Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн багш	500000	500000
Нийт мөнгөн дүн				1500000

Төсөв гаргасан:

Б.Оюун  
/АЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтэн/

Төсөв хянасан:

Ц.Уранцэцэг  
/АЗДТГ-ын тооцооны нягтлан бодогч /